



НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН  
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,  
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160 0035  
Утас: (976-11) 32 71 99  
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024. 04. 04 № 05 | 1773  
танай -ны № -т

Захирамж хүргүүлэх тухай


Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны ажил дүгнэх тухай" А/349 дүгээр захирамжийг хавсралтаар хүргүүлж байна.

Тус захирамжаар "Бүрэн хангалттай" үнэлгээ авсан байгууллагууд батлагдсан төсвийн хүрээнд идэвх, санаачилгатай ажилласан удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагчдаа зохих хууль, журмын дагуу урамшуулах, "Ажил сайжруулах шаардлагатай" үнэлгээ авсан байгууллагууд албан тушаалтан, ажилтан, албан хаагчдынхаа сахилга, хариуцлагыг өндөржүүлж, ажлын цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулж, төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, зааврын дагуу байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл үр дүнг сайжруулан, төрийн албаны стандартыг мөрдөж, дотоод хяналтыг сайжруулж ажиллахыг мэдэгдье.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГА

Л.ХОСБАЯР



1110201439



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар A/349

Улаанбаатар хот

### Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны ажил дүгнэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг хавсралтаар тус тус баталсугай.

2. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" болон "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", "Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө", 2024 оныг "Тохижилт-Бүтээн байгуулалтын жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага наарт үүрэг болгосугай.

3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах, хариуцсан албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах сургалтад үе шаттайгаар хамруулж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Л.Хосбаяр)-т үүрэг болгосугай.

4. Төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, албан хаагчдыг давтан сургаж, мэргэшүүлэх дунд болон богино хугацааны сургалтад хамруулж, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй нь уялдуулан ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

5. Нийслэлийн өмчийн үр ашгийг дээшлүүлж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, орлого, үр дүнг нэмэгдүүлэн, авлага, өр төлбөрийг бууруулж, үйл ажиллагааны менежментийг сайжруулан ажиллахыг орон нутгийн өмчит төсөвт болон аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлуудад үүрэг болгосугай.

6.2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээнд хамрагдсан байгууллагуудад үүрэг даалгавар, зөвлөмж хүргүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Х.Гантулга)-т, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг хагас, бүтэн жилээр холбогдох хэлтэст тайлагнаж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага наарт тус тус үүрэг болгосугай.

7.Үйл ажиллагааны үнэлгээгээр “Ажил сайжруулах шаардлагатай” үнэлгээ авсан байгууллага, удирдлагад хугацаатай үүрэг даалгавар өгч, үр дүнг тооцож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Л.Хосбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР



Нийслэлийн Засаг даргын 2024 оны  
...03.09.2024.....сарын 29... өдрийн  
...4/3.9.2024.....захирамжийн  
хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН  
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН  
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Нэг. Дүүргийн Засаг дарга, Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ:

Бүрэн хангалттай: (Үсгийн дарааллаар)

Налайх дүүрэг  
Сонгинохайрхан дүүрэг  
Хан-Уул дүүрэг

Хангалттай: (Үсгийн дарааллаар)

Багануур дүүрэг  
Багахангай дүүрэг  
Баянгол дүүрэг  
Баянзүрх дүүрэг  
Сүхбаатар дүүрэг  
Чингэлтэй дүүрэг

Хоёр. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ:

Бүрэн хангалттай: /Үсгийн дарааллаар/

Нийтлэг үйлчилгээний газар  
Онцгой байдлын газар  
Хотын стандарт, хяналтын газар  
Цагдаагийн удирдах газар

Хангалттай: (Үсгийн дарааллаар)

Архивын газар  
Бизнес инновац хөгжлийн газар  
Боловсролын газар  
Газар зохион байгуулалтын алба  
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар  
Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар  
Дотоод аудитын алба  
Замын хөгжлийн газар  
Нийгмийн даатгалын газар  
Орон сууцны бодлогын газар  
Өмчийн харилцааны газар  
Соёл, урлагийн газар  
Улсын бүртгэлийн газар

Хот байгуулалт, хөгжлийн газар  
 Хөдөлмөр, халамжийн газар  
 Худалдан авах ажиллагааны газар  
 Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар

Ажил сайжруулах шаардлагатай: (Үсгийн дарааллаар)

Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар  
 Аялал жуулчлалын газар  
 Байгаль орчны газар  
 Биеийн тамир, спортын газар  
 Мал эмнэлгийн газар  
 Нийтийн тээврийн газар  
 Статистикийн газар  
 Татварын газар  
 Хүнс, хөдөө аж ахуйн газар  
 Эрүүл мэндийн газар

Гурав. Орон нутгийн өмчит төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ:

Бүрэн хангалттай: (Үсгийн дарааллаар)

Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих төв  
 Монголын хүүхдийн ордон  
 Нийслэлийн Төр захирагааны Авто бааз

Хангалттай: (Үсгийн дарааллаар)

Багануур үйлдвэрлэл, технологийн парк  
 Багахангайн үйлдвэрлэл технологийн парк  
 Бодлогын судалгаа, шинжилгээний төв  
 Монгол наадам цогцолбор  
 Монголын Хүүхдийн урлан бүтээх төв  
 Налайх Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк  
 Нийгмийн хамгааллын тусгай төв  
 Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төв  
 Соёлын төв өргөө  
 Улаанбаатар лифт  
 Улаанбаатар театр  
 Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж  
 Улаанбаатар хотын музей  
 Улаанбаатар хотын Нийтийн номын сан  
 Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв  
 Үндэсний цэцэрлэгт хүрээлэн  
 Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор

Ажил сайжруулах шаардлагатай: (Үсгийн дарааллаар)

Бэлчээрийн мэнежментийн төслийн нэгж

Дөрөв. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ:

Бүрэн хангалттай: (Үсгийн дарааллаар)

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ  
Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ  
Улаанбаатар хотын Үс сувгийн удирдах газар ОНӨААТҮГ  
Хот тохижилтийн газар ОНӨААТҮГ

Хангалттай: (Үсгийн дарааллаар)

Асгат ОНӨААТҮГ  
Багачууд хүнс ОНӨААТҮГ  
Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ  
Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ  
Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ  
Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ  
Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ  
Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ  
Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ  
Хүнс хангамж төв ОНӨААТҮГ  
Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ